

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_\_\_

Улаанбаатар хот

## Журам батлах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1."Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, аюулгүй байдлыг хангах, ашиглах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакирт даалгасугай.

Гарын үсэг

Засгийн газрын 2026 оны  
\_\_\_\_\_ дугаар тогтоолын хавсралт

## **ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БҮРДҮҮЛЭХ, ХАДГАЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, АШИГЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 48.4-т заасан Хүүхэд хамгааллын мэдээллийн нэгдсэн сан (цаашид "мэдээллийн сан" гэх)-г бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2.Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах, хамгаалах, мэдээлэл солилцох чиг үүрэгтэй эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн, хуулийн этгээд энэ журмыг мөрдөж ажиллана.

1.3.Мэдээллийн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.4.Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, мэдээлэл солилцохтой холбоотой бүхий л үйл ажиллагаанд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих бөгөөд гагцхүү хүүхдийн сайн сайхан байдлыг хангах зорилгоор мэдээллийг цуглуулж, ашиглана.

1.5.Мэдээллийн сангийн мэдээлэл хариуцагч нь хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага байна.

### **Хоёр. Мэдээллийн сангийн зорилго, бүрэлдэхүүн, эх үүсвэр**

2.1.Мэдээллийн сан нь дараах зорилготой байна:

2.1.1.хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах, хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангах үйл ажиллагааг мэдээллээр дэмжих;

2.1.2.эрсдэлт нөхцөлд байгаа болон эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийг эрт илрүүлэх, нөхцөл байдлыг үнэлэх, шаардлагатай хүүхэд хамгааллын үйлчилгээг цаг алдалгүй хүргэхэд дэмжлэг үзүүлэх;

2.1.3.хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг хянах, үнэлэхэд шаардлагатай мэдээллийн үндсийг бүрдүүлэх;

2.1.4.хүүхэд хамгааллын кейсийн бүртгэл, үйл явцыг хөтлөх, үйлчилгээний үр дүнг хянах замаар тасралтгүй, уялдаа холбоотой үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

2.1.5.хүүхэд хамгааллын талаар үүрэг хүлээсэн төрийн болон бусад байгууллагын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог шуурхай, аюулгүй, үр ашигтай зохион байгуулах;

2.1.6.хүүхэд хамгааллын бодлого боловсруулах, төлөвлөх, шийдвэр гаргах үйл ажиллагааг мэдээллээр хангах;

2.1.7.судалгаа, статистикийн зорилгоор хүүхдийг таних боломжгүй болгосон нэгтгэсэн мэдээллийн сан бүрдүүлэх;

2.1.8.хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах, мөлжлөг зэрэг эрсдэлийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх;

2.1.9.хүүхэд хамгааллын үйлчилгээний ил тод байдал, хариуцлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

2.2.Мэдээллийн сангийн мэдээлэл нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15.1-д кейс менежентийн үе шат бүрд хамаарах дараах мэдээллээс бүрдэнэ:

2.2.1.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн болон түүний хууль ёсны төлөөлөгчийн мэдээлэл;

2.2.2.нөхцөл байдлын үнэлгээ: (аюулын зэргийн үнэлгээ, эрсдэлийн үнэлгээ, гэр бүлийн давуу болон сул талын үнэлгээ);

2.2.3.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, авсан арга хэмжээ, холбогдох шийдвэр, баримт бичиг;

2.2.4.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үйлчилгээ үзүүлэгч этгээдийн мэдээлэл.

2.3.Энэ журмын 2.2-т мэдээллийн хууль тогтоомжид заасан үндэслэлээр дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

2.3.1.төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан авсан мэдээлэл;

2.3.2.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч этгээдээс оруулсан мэдээлэл;

2.3.3.хуульд заасан чиг үүрэг бүхий бусад байгууллагаас оруулсан мэдээлэл.

## **Гурав. Мэдээллийн санг ашиглах**

3.1.Мэдээллийн сан дахь мэдээллийг дараах зорилгоор ашиглана:

- 3.1.1.хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, кейсийг шийдвэрлэх;
- 3.1.2.хүүхэд хамгааллын бодлого боловсруулах, төлөвлөх;
- 3.1.3.хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;
- 3.1.4.судалгаа, статистик гаргах.

3.2.Мэдээллийг анх цуглуулсан зорилгоос өөрөөр ашиглахыг хориглоно.

3.3.Мэдээллийн санг ашиглах хэрэглэгчийн эрхийн түвшинг албан тушаал, чиг үүрэг, оролцож буй кейс зэрэгтэй уялдуулан олгох, мэдээлэлд хандах хязгаарлалтыг тогтооно.

3.4.Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.3-т заасны дагуу мэдээллийн сангийн хэрэглэгчийн эрхийг олгох, сунгах, мэдээллийг хууль бусаар ашигласан хэрэглэгчийн эрхийг цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

3.5.Хэрэглэгч мэдээллийн үнэн зөв оруулах, мэдээллийн нууцлалыг хадгалах, хууль бусаар бусдад задруулахгүй байх, мэдээллийн системээс гадуур мэдээллийг дамжуулахгүй байх, өөрийн үйлдлийн бүртгэлийн үр дагаврыг бүрэн хариуцах үүрэгтэй.

3.6.Хэрэглэгч өөрийн чиг үүрэгт хамаарахгүй мэдээлэлд хандахыг хориглох бөгөөд мэдээллийг зөвхөн өөрийн чиг үүргийн хүрээнд ашиглана.

3.7.Хүүхдийн хувийн болон эмзэг мэдээллийг гагцхүү хүүхдийн сайн сайхан байдлыг хангах зорилгын хүрээнд мөрдөн шалгах байгууллага болон боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан зэрэг хүүхэд хамгааллын үйлчилгээнд оролцогч төрийн байгууллага руу аюулгүй сувгаар, бүртгэлтэйгээр дамжуулна.

3.8.Мэдээллийг судалгаа, статистикийн зорилгоор ашиглахдаа хүүхдийн хувийн мэдээллийг таних боломжгүй болгосон байна.

## **Дөрөв. Мэдээллийн сангийн удирдлага, зохион байгуулалт**

4.1.Хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.мэдээллийн санг удирдах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах, мэдээлэл солилцох, салбар дундын уялдаа, хамтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

4.1.2.мэдээллийн санд оруулах энэ журмын 2.2.1, 2.2.3, 2.2.4-т заасан мэдээллийн бүрдэл маягтыг батлах;

4.1.3.энэ журмын 3.3-т заасны дагуу мэдээллийн санг ашиглах хэрэглэгчийн эрхийн түвшин, түүний мэдээлэлд хандах хязгаарлалтыг тогтоох;

4.1.4.мэдээллийн сангийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

4.1.5.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

4.2.Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1.мэдээллийн сангийн өдөр тутмын ашиглалт, мэдээллийг бүрдүүлэх, шинэчлэх, засварлах үйл ажиллагааг зохион байгуулах;

4.2.2.мэдээллийн системийн хөгжүүлэлт, хэвийн, найдвартай, аюулгүй байдлыг хангаж ажиллах;

4.2.3.мэдээллийн санд оруулж байгаа мэдээллийн үнэ зөв байдлыг шалгаж, мэдээллийн давхардал, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

4.2.4.мэдээллийн санг ашиглах хэрэглэгчийн эрхийг энэ журмын 4.1.3-т заасанд нийцүүлэн олгох, мэдээллийг хууль бусаар ашигласан хэрэглэгчийн эрхийг түдгэлзүүлэх, цуцлах;

4.2.5.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

#### **Тав. Мэдээллийн сангийн хамгаалалт, аюулгүй байдал**

5.1.Мэдээллийн санг мэдээлэл хариуцагч болон Үндэсний дата төвд байршуулах бөгөөд нөөц болон толин серверийн дэд бүтэцтэй байна.

5.2.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ журмын 1.3-т заасан мэдээлэл хариуцагч нь мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.3.Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангахдаа Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 7.1-д заасан нийтлэг журам болон мөн хуулийн 7.2-т заасан кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журмыг дагаж мөрдөнө.

5.4.Мэдээлэл хариуцагч нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17.1.6-д заасан эрсдэлийн үнэлгээг хуульд заасан хугацаанд хийлгэнэ.

5.5.Мэдээллийн санд холбогдож ажиллаж байгаа программ хангамжууд болон нууцлалын шифрлэлт (SSL) нь албан ёсны эрхтэй байна.

5.6.Мэдээллийн санд хийсэн үйлдэл тус бүрээр бүртгэлийн түүх үүсгэж хадгална.

5.7.Мэдээлийн сан, түүний нөөц хувилбарыг Архивын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид хугацаанд хадгална.

### **Зургаа. Бусад**

6.1.Мэдээллийн санг бүрдүүлэх, удирдах, ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангахтай холбогдох зардлыг улсын төсөв болон үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөр, дотоод, гадаадын хуулийн этгээд болон олон улсын байгууллага, хувь хүнээс өгсөн хандив, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

6.2.Мэдээллийн сан дахь мэдээллийг хууль бусаар ашигласан, задруулсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---